



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-Д БҮРТГЭЛТЭЙ  
НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУД  
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

**Гүйцэтгэсэн:**

А.Авир, дарга  
Л.Мөнхзаяа, ахлах референт  
Ж.Лхагвамядаг, мэргэжилтэн  
Б.Арьяаманал, мэргэжилтэн

## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-Д БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧДЫН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТ - 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

### 1. ҮЙЛ ЯВЦЫН ӨРНӨЛ

#### 2006 он

Монгол Улсын Их хурлаас “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийг баталж, компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох бүрэн эрхийг тус Хороонд олгов.

#### 2007 он

“Монгол компанийн засаглалын кодекс”-ийг Хороо анх удаа батлав.

#### 2014 он

“Компанийн засаглалын кодекс”-т нэмэлт, өөрчлөлт оров.

#### 2022.03.23

Хорооны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийн шинэчилсэн найруулга батлагдлаа. Шинэчилсэн кодексийн хавсралтаар олон улсад түгээмэл ашиглагддаг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмаар үнэлгээний аргачлал бүхий тайлангийн маягт болон компанийн дотооддоо баталж, мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журмын зааврын үлгэрчилсэн загваруудыг батлав.

#### 2022.04.15

Кодекс “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл”-д бүртгэгдэж, эрх зүйн мэдээллийн [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) нэгдсэн системд байршсанаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн ба нээлттэй хувьцаат компани, даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага болон хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд дагаж мөрдөх үүргийг хүлээв.

#### 2022.06.22

Хорооны даргын 2022 оны 336 дугаар тушаалаар “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж”-ийг баталж, компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх нэгдсэн зохион байгуулалт, зах зээлд оролцогч талуудын баримтлах зарчим, чиг үүргийг тодорхойлов.

#### 2022.11.03

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 1 болон 2 дугаар ангилалд бүртгэлтэй нийт 66 ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагыг оролцуулан кодексийн хэрэгжилтийн үнэлгээг хэрхэн тайлагнах сэдвээр нийтдээ 6 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.

**2022.12.30**

Хорооны зохицуулалтын 3 салбарын нийт 116 зохицуулалттай этгээд /даатгагч, хөрөнгө оруулалтын менежментийн компани, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага/-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэн тайлангийн хариугаар заавар зөвлөмж, эсхүл хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь тооцон салбар тус бүрийн зэрэглэлийг тогтоож, нийтэд мэдээлэв. Үнэлгээг хянан баталгаажуулахад, 2022 оны 8 дугаар сарын байдлаар кодексийн хэрэгжилтийн анхны буюу нөхцөл байдлын үнэлгээ 55.3 хувийн гүйцэтгэлтэй байсан бол Хорооноос үнэлгээний тайлангийн хариугаар компани тус бүрд зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, мөн оны 12 дугаар сард биелэлтийг нь тооцсон давтан үнэлгээгээр зохицуулалттай 3 салбарын кодексийн хэрэгжилт дунджаар 16.4 хувиар өсөв.

**2023.01.02**

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлтэй хувьцаат компаниудын кодексийн хэрэгжилтийг үнэлэх ажлыг эхлүүлэв.

**2023.03.01**

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 1, 2 дугаар ангиллын 68 ХК, 3 дугаар ангилалд бүртгэлтэй 40 ХК, нийт 108 ХК-ийн кодексийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч, хянан баталгаажуулан тайлан тус бүрийн хариугаар хугацаатай үүрэг, даалгавар өгөгдөв.

**2023.06.30**

Кодексийн анхдагч үнэлгээний хариугаар Хороонд ирүүлсэн нийт 47 үнэт цаас гаргагчийн тайланг давтан үнэлж, ахиц дэвшлийг тогтооход кодексийн хэрэгжилт дунджаар 12.7 хувиар өсжээ. Ингэснээр компанийн засаглалын чанар буюу кодексийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнд суурилсан зэрэглэл тогтоож эхлэв. Кодексийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлж, нэгдсэн тайлан гаргаж, зэрэглэл тогтоосноор компанийн засаглалын өнөөгийн нөхцөл байдал, эрсдэл, чиг хандлагыг тодорхойлон зохицуулалтын орчныг оновчтой болгох, үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргахад нь шаардлагатай чанарын үзүүлэлтүүд бий болов.

**2023.12.28**

Даатгагч, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн зэрэг 124 тусгай зөвшөөрөлтэй компанийн кодексийн хэрэгжилтийг хянан баталгаажуулахад 2023 оны эцсийн байдлаар дундаж үнэлгээ 2022 оныхоос 30 гаруй хувиар дээшилсэн дүн гарлаа. Хөрөнгийн биржид бүртгэлтэй 104 ХК-ийн кодексийн хэрэгжилтийн үнэлгээ оны эцсээр 17 гаруй хувийн ахиц дэвшлийг үзүүлэв.

**2024.02.08**

Хорооны даргын 2024 оны 52 дугаар тушаалаар “Комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал” батлагдав. Энэхүү аргачлалыг таниулж, нэвтрүүлэх зорилгоор даатгагч, хөрөнгө оруулалтын менежментийн компани, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын эрх бүхий албан тушаалтнуудад “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, комплайнсын эрсдэлийг үнэлэх нь” сэдвээр нийтдээ 3 удаагийн сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулав.

**2024.06.28**

Хөрөнгийн биржид бүртгэлтэй 108 ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэн, үнэлгээний тайлангийн хариугаар компани тус бүрд зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг 2024 оны хагас жилийн байдлаар тооцон тайлангаа ирүүлсэн 37 компанийн давтан үнэлгээг хянан баталгаажуулахад кодексийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 18.7 хувиар өсөв.

## **2. СУДАЛГААНЫ ТАЛААР**

Компанийн засаглалыг нэвтрүүлэх нь бизнесийн үйл ажиллагааны урт хугацааны өгөөжийг хангах төдийгүй хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн хүлээлтэд суурилсан шударга, нээлттэй зах зээлийн орчин бүрдэхэд эергээр нөлөөлдөг тул нийгэмд ач холбогдолтой энэ сэдвийг онцгойлон анхаарч, тогтмол хөгжүүлэх шаардлагатай.

Олон улсын практикийн дагуу компанийн засаглалын чанар, кодексийн хэрэгжилтийг үнэлэхдээ эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн зэрэглэл тогтоох аргыг ашиглав.

Компанийн засаглалын зэрэглэл нь тухайн компанийн үйл ажиллагаанд эрсдэлийн дүн шинжилгээ хийх мэдээлэл болж өгснөөр хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрсдэлгүй шийдвэр гаргалтад эергээр нөлөөлнө.

## **3. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ**

- “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлж нэгдсэн тайлан боловсруулах;
- компанийн засаглалын хандлага, учирч болох эрсдэлийг тодорхойлох;
- хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч эрсдэлийн үнэлгээ хийж, шийдвэр гаргах засаглалын үзүүлэлтийг бий болгох;
- үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн ангилал бүрээр засаглалаар тэргүүлэгчдийг тодруулах, компанийн засаглалын зэрэглэл тогтоох;
- нээлттэй хувьцаат компаниудад өөрийн засаглалыг харьцуулах, сайжруулахад чиг баримжаа болох компанийн засаглалын жишгийг тодорхойлох;
- хууль тогтоомж болон хувьцаат компанийн баталсан дотооддоо дагаж мөрдөх дүрэм, журмын эрх зүйн орчныг оновчтой болгож, сайжруулах;
- хугацааны цуваа хэлбэрээр статистик мэдээллийг үүсгэх.

## 4. АРГАЧЛАЛ

Судалгаа нь “Компанийн засаглалын кодекс”-ийн 36 зүйлийн хэрэгжилтийн асуумжаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй 108 ХК-ийн анхны үнэлгээ, 37 ХК-ийн давтан үнэлгээний тайлангууд болон Хорооноос хэрэгжүүлсэн судалгааны үр дүнд суурилсан.

### 4.1. СУДАЛГААНЫ ГОЛЛОХ СЭДЭВ:

**а. ТУЗ болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагаа, бүтэц, бүрэлдэхүүн.**

**б. дотоод эрх зүйн зохицуулалтын ил тод байдал /цахим хуудасны шинэчлэл/:**

- бодлогын баримт бичиг;
- ёс зүйн дүрэм;
- компанийн дүрэм, дотоод үйл ажиллагааны журам;
- мэдээллийн ил тод байдал, тайлагнал, комплайнсын хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны журам, заавар;
- компанийн эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр.

**в. хамгийн сайн болон муу хэрэгжсэн засаглалын үзүүлэлтүүд.**

### 4.2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН:

**“Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниуд:**

а. Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс нийт 108 хувьцаат компанид анхны үнэлгээг хийж, тайлангийн хариугаар хугацаатай үүрэг бүхий албан тоот хүргүүлснээр нийт 37 компанийн давтан зайны үнэлгээг кодексийн хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлэв.


б. Компаниудын ирүүлсэн зайны үнэлгээг хавсаргасан нотлох баримтад үндэслэн үнэлгээний хяналтын оноо болон хувиар нэгдсэн дүнг тооцов.

в. Үнэлгээний нэгдсэн дүнг үндэслэн компани тус бүрд тухайлсан зөвлөмж, чиглэл хүргүүлэн тэдгээрийн биелэлтээр зайны үнэлгээний ахиц дэвшлийг тодорхойлов.

Компанийн үнэлгээний нэгдсэн дүн нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэл хийхтэй холбоотойгоор Хорооноос холбогдох шийдвэр гаргах, компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон эрх зүйн орчныг боловсронгуй, оновчтой болгох чиглэлд дүн шинжилгээ хийх, мөн компанийн засаглалын зэрэглэлийн нэгдсэн судалгааг гарган нийтлэх, мэдээллийн зорилгоор ашиглагдана.

### 5. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

ДҮРСЛЭЛ 1. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНД СУУРИЛСАН ХУГАЦААТАЙ ЧИГЛЭЛ, ҮҮРГИЙН ДАГУУ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ:




Шигтгээ 1:

Давтан үнэлгээгээр нийт **37** ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ дунджаар **18.7** хувиар өсөлтийг үзүүлэв


Шигтгээ 2:

Хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй компаниуд **23.1**, 2-р ангилал **24.6**, 3-р ангиллын үзүүлэлт **8.4** хувиар тус тус өсөв


ДҮРСЛЭЛ 2. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН БИРЖИЙН БҮРТГЭЛИЙН АНГИЛЛЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ:




**ДҮРСЛЭЛ 3. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХАРИЛЦАН ХАМААРАЛ:**




**ДҮРСЛЭЛ 4. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХАРИЛЦАН ХАМААРАЛ (100.0 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨС ДЭЭШ)**



**ДҮРСЛЭЛ 5. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХАРИЛЦАН ХАМААРАЛ (10.0-100.0 ТЭРБУМ ТӨГРӨГ ХҮРТЭЛ)**



**ДҮРСЛЭЛ 6. "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХАРИЛЦАН ХАМААРАЛ (10.0 ТЭРБУМ ТӨГРӨГ ХҮРТЭЛ)**



**Шигтгээ 3:**

"Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн болон Зах зээлийн үнэлгээ, бүртгэлийн ангиллын хооронд харилцан хамаарал ажиглагдлаа


**ДҮРСЛЭЛ 7. ЦАХИМ ХУУДСАНДАА ИЛ БОЛГОСОН МЭДЭЭЛЭЛ:**





## 6. “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН БҮРТГЭЛИЙН 1-Р АНГИЛАЛ

ДҮРСЛЭЛ 8. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:



Шигтгээ 4:

Хөрөнгийн биржийн 1 дүгээр ангилалд бүртгэлтэй 12 компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 23.1 хувиар өсөв

ДҮРСЛЭЛ 9. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:



3-5 хараат бус гишүүн

6-8 энгийн гишүүн


Шигтгээ 5:

ТУЗ-ийн бүрэлдэхүүн 9-12 гишүүнтэй, 34.0 хувь нь хараат бус


Шигтгээ 6:

Нийт ТУЗ-ийн гишүүдийн 29.0 хувь нь эмэгтэйчүүд

ДҮРСЛЭЛ 10. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:




ДҮРСЛЭЛ 11. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА /Жилээр/:



ДҮРСЛЭЛ 12. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:



ДҮРСЛЭЛ 13. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:




ДҮРСЛЭЛ 14. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД ТУС БҮРИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХУРАЛДСАН ХУРАЛ БОЛОН ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТОО /Дунджаар/:



Шигтгээ 7: ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 3–5 гишүүнтэй

**ДҮРСЛЭЛ 15. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:**




- Мэдээлэл бүрэн байршуулсан
- Мэдээлэл дутуу байршуулсан
- Шинэчлэлт хийж байгаа
- Цахим хуудасгүй

**Шигтгээ 8:**  
 2024 оны эхний хагас жилийн байдлаар **85.0** хувь нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулав


**Шигтгээ 9:**  
 Тайлант хугацаанд **78.0** хувь нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгов

**ДҮРСЛЭЛ 16. САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН КОДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:**

**Хамгийн сайн хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:**




**Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:**




**7. “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН БҮРТГЭЛИЙН 2-Р АНГИЛАЛ**

ДҮРСЛЭЛ 17. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:



Шигтгээ 10:  
 Хөрөнгийн биржийн 2 дугаар ангилалд бүртгэлтэй 15 компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 24.6 хувиар өсөв


ДҮРСЛЭЛ 18. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:




Шигтгээ 11:  
 ТУЗ 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээс 33.0 хувь нь хараат бус гишүүд

Шигтгээ 12:  
 ТУЗ-ийн бүрэлдэхүүний 28.0 хувь нь эмэгтэй гишүүд

ДҮРСЛЭЛ 19. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:




*ДҮРСЛЭЛ 20. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА /Жилээр/:*



*ДҮРСЛЭЛ 21. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:*



*ДҮРСЛЭЛ 22. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:*




**ДҮРСЛЭЛ 23. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХУРАЛДСАН ХУРАЛ БОЛОН ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТОО /Дунджаар/:**



Шигтгээ 13:  
 ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 3–5 гишүүнтэй



**ДҮРСЛЭЛ 24. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:**



Шигтгээ 14:  
 2024 оны эхний хагас жилийн байдлаар 84.0 хувь нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулав

Шигтгээ 15:  
 Тайлант хугацаанд 53.0 хувь нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгов


## ДҮРСЛЭЛ 25. САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН КОДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Хамгийн сайн хэрэгжсэн компанийн  
засаглалын үзүүлэлтүүд:Хамгийн сул хэрэгжсэн компанийн  
засаглалын үзүүлэлтүүд:



## 8. “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН БҮРТГЭЛИЙН 3-Р АНГИЛАЛ

ДҮРСЛЭЛ 26. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:



**Шигтгээ 16:**  
 Хөрөнгийн биржийн 3 дугаар ангилалд бүртгэлтэй 10 компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 8.4 хувиар өсөв

ДҮРСЛЭЛ 27. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:




**3-4** хараат бус гишүүн  
**5-6** энгийн гишүүн


**Шигтгээ 17:**  
 ТУЗ нь 9 гишүүнтэйгээс 30.0 хувь нь хараат бус гишүүд

**Шигтгээ 18:**  
 ТУЗ-ийн бүрэлдэхүүний 35.0 хувь нь эмэгтэй

ДҮРСЛЭЛ 28. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:




**ДҮРСЛЭЛ 29. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРЦЛАГА /Жилээр/:**



**ДҮРСЛЭЛ 30. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:**



**ДҮРСЛЭЛ 31. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:**




**ДҮРСЛЭЛ 32. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХУРАЛДСАН ХУРАЛ БОЛОН ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТОО:**



Шигтгээ 19:  
 ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 3–5 гишүүнтэй

**ДҮРСЛЭЛ 33. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:**




Шигтгээ 20:  
 2024 оны эхний хагас жилийн байдлаар 48.0 хувь нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулав


Шигтгээ 21:  
 Тайлант хугацаанд 67.0 хувь нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгов

**ДҮРСЛЭЛ 34. САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН КОДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:**

**Хамгийн сайн хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:**



**Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:**



**9. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭГЭЭР ТЭРГҮҮЛЭГЧ ТОП 20 /Цагаан толгойн дарааллаар жагсаав/**

- |                                   |                          |
|-----------------------------------|--------------------------|
| 1. “АРД КРЕДИТ ББСБ” ХК           | 11. “ПРЕМИУМ НЭКСУС” ХК  |
| 2. “АПУ” ХК                       | 12. “СҮҮ” ХК             |
| 3. “БОДЬ ДААТГАЛ” ХК              | 13. “СЭНДЛИ ББСБ” ХК     |
| 4. “БУЛИГААР” ХК                  | 14. “ТЕХНИК ИМПОРТ” ХК   |
| 5. “ГОВЬ” ХК                      | 15. “ТӨРИЙН БАНК” ХК     |
| 6. “ИНВЕСКОР ББСБ” ХК             | 16. “ТҮМЭН ШУВУУТ” ХК    |
| 7. “ЛЭНДМН ББСБ” ХК               | 17. “УЛААНБААТАР-БҮК” ХК |
| 8. “МОНГОЛ БАЗАЛТ” ХК             | 18. “ХАС БАНК” ХК        |
| 9. “МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХК | 19. “ШИВЭЭ ОВОО” ХК      |
| 10. “МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ” ХК     | 20. “ЭРЭЭНЦАВ” ХК        |

**10. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР БАЙР ЭЗЛҮҮЛСЭН ЗЭРЭГЛЭЛ /Давтан үнэлгээ ирүүлсэн компанийг ногооноор тодруулав/**

Байр	Компанийн нэрс	Байр	Компанийн нэрс
1	"ГОВЬ" ХК	55	"ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК
2	"СҮҮ" ХК	56	"ХАСУ-МАНДАЛ" ХК
3	"МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ" ХК	57	"АДУУН ЧУЛУУН" ХК
4	"ЭРЭЭНЦАВ" ХК	58	"ТАХЬ-КО" ХК
5	"ИНВЕСКОР ББСБ" ХК	59	"ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК" ХК
6	"МОНГОЛ БАЗАЛТ" ХК	60	"КРИПТО ҮНДЭСТЭН" ХК
7	"ПРЕМИУМ НЭКСУС" ХК	61	"ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ" ХК
8	"ТӨРИЙН БАНК" ХК	62	"БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК" ХК
9	"ЛЭНДМН ББСБ" ХК	63	"МОН НАБ" ХК
10	"СЭНДЛИ ББСБ" ХК	64	"РЕМИКОН" ХК
11	"ТЕХНИК ИМПОРТ" ХК	65	"ХАЙ БИ ОЙЛ" ХК
12	"ТҮМЭН ШУВУУТ" ХК	66	"ГАН ХИЙЦ" ХК

13	"УЛААНБААТАР-БҮК" ХК	67	"МОНГОЛ АЛТ" ХК
14	"ХАС БАНК" ХК	68	"АЛТАЙН ЗАМ" ХК
15	"МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО" ХК	69	"ТЭЭВЭР ДАРХАН" ХК
16	"ШИВЭЭ ОВОО" ХК	70	"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХК
17	"АПУ" ХК	71	"ТАВИЛГА" ХК
18	"БОДЬ ДААТГАЛ" ХК	72	"ХАРХОРИН" ХК
19	"БУЛИГААР" ХК	73	"АТАР-ӨРГӨӨ" ХК
20	"АРД КРЕДИТ ББСБ" ХК	74	"МОНГЕО" ХК
21	"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК	75	"ИХ БАРИЛГА" ХК
22	"ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК" ХК	76	"МОГОЙН ГОЛ" ХК
23	"БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ" ХК	77	"ХОРИН ХОЁРДУГААР БААЗ" ХК
24	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	78	"БЭРХ УУЛ" ХК
25	"Э-ТРАНС ЛОЖИСТИКС" ХК	79	"МОНГОЛ ШИЛТГЭЭН" ХК
26	"БОГД БАНК" ХК	80	"АРИГ ГАЛ" ХК
27	"АЙТҮҮЛС" ХК	81	"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК
28	"ГЕРМЕС ЦЕНТР" ХК	82	"ДАРХАН ХҮНС" ХК
29	"МАНДАЛ ДААТГАЛ" ХК	83	"ЭРДЭНЭТ УС, ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК
30	"ХААН БАНК" ХК	84	"БАЯН ТЭЭГ" ХК
31	"ДАРХАН НЭХИЙ" ХК	85	"МОНГОЛ САВХИ" ХК
32	"МОНГОЛ ДААТГАЛ" ХК	86	"АРВИЖИХ" ХК
33	"БИ ДИ СЕК ҮЦК" ХК	87	"ДЭВШИЛ МАНДАЛ" ХК
34	"ГОЛОМТ БАНК" ХК	88	"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК
35	"МИК ХОЛДИНГ" ХК	89	"АЗЫК" ХК
36	"БАГАНУУР" ХК	90	"БҮТЭЭЛЧ ҮЙЛС" ХК
37	"ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС" ХК	91	"ГУТАЛ" ХК
38	"МОНОС ХҮНС" ХК	92	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
39	"ХОТ ДЕВЕЛОПМЕНТ" ХК	93	"ДОРНОД ХУДАЛДАА" ХК
40	"НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ" ХК	94	"ЖЕНКО ТУР БҮРО" ХК
41	"ТАЛХ ЧИХЭР" ХК	95	"И ЭС ЖИ ФАЙНАНС" ХК
42	"ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ" ХК	96	"ЛЮКС ЗАНАДУ ГРУПП" ХК
43	"УЛААНБААТАР ХИВС" ХК	97	"МАТЕРИАЛИМПЭКС" ХК
44	"ЖИДАКС" ХК	98	"МЕРЕКС" ХК
45	"УВС ХҮНС" ХК	99	"МОНГОЛ НЭХМЭЛ" ХК
46	"АРД ДААТГАЛ" ХК	100	"НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ" ХК
47	"ЭРЧИМ БАЯН-ӨЛГИЙ" ХК	101	"СИЛИКАТ" ХК
48	"МАХИМПЕКС" ХК	102	"СОР" ХК
49	"МОНГОЛ ШУУДАН" ХК	103	"СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП" ХК
50	"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК	104	"ТАВАН ТОЛГОЙ" ХК
51	"ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП" ХК	105	"ХИШИГ УУЛ" ХК
52	"МОНИНЖБАР" ХК	106	"ХӨВСГӨЛ" ХК
53	"ӨНДӨРХААН" ХК	107	"ШАРЫН ГОЛ" ХК
54	"ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП" ХК	108	"ЭМ ЭН ДИ" ХК

-oOo-